



БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН 2017 оны II улирал

Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан арилжааны банкуудын зээлийн төлөвийн талаарх түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн тайлагнасан тул Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

2017 оны 6 дугаар сар



1 СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

Өнгөрсөн 3 сарын хугацаанд:

- Том болон жижиг банкууд Аж ахуйн нэгж (ААН)-ийн зээлийн тэр дундаа барилгын салбарын зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулсан бол дунд банкуудын хувьд зээлийн шалгуурт өөрчлөлт оруулаагүй байна;
- Өрхийн зээлийн шалгуурыг жижиг банкууд бага зэрэг сулруулсан бол том болон дунд банкуудын хувьд өөрчлөөгүй байна;
- Нийт банкуудын хувьд зээлийн хэмжээгээ бууруулах, барьцаа хөрөнгийн үнэлгээг бууруулж шаардлагаа өсгөх мөн зээлдэгчийн гэрээгээр хүлээх үүргийг нэмэгдүүлэх зэргээр ААН-ийн зээлийн нөхцөлүүдээ бага зэрэг чангаруулсан бол өрхийн зээлийн нөхцөлд төдийлөн өөрчлөлтийг оруулаагүй байна;
- Том банкуудын хувьд ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг өссөн бол бусад банкуудын ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг буурсан байна;
- Уул уурхайн салбар дахь зээлийн эрэлт өссөн бол хөдөө аж ахуйн салбар дахь зээлийн эрэлт буурсан байна;
- Нийт банкуудын хувьд өрхийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн байна.

Хүснэгт 1: Түүвэр судалгааны нэгдсэн үр дүн

	Зээлийн шалгуур		Зээлийн нөхцөл		Зээлийн эрэлт	
	ААН	Өрхийн	ААН	Өрхийн	ААН	Өрхийн
Өнгөрсөн 3 сарын хугацаанд						
Том банкууд	↑	0	↑	0	↓	↓
Дунд банкууд	0	0	↑	↓	↑	↓
Жижиг банкууд	↑	↓	↑	↓	↑	↓
Ирэх 3 сарын хугацаанд						
Том банкууд	0	0	0	0	↑	0
Дунд банкууд	0	↓	↓	↓	↑	↑
Жижиг банкууд	↓	0	↓	↓	↑	↑

Тэмдэглэл : ↑ бага зэрэг чангарсан , ↓ бага зэрэг суларсан, ↑ бага зэрэг нэмэгдэх, ↓ бага зэрэг буурах, 0 өөрчлөгдөөгүй

Ирэх 3 сарын хугацаанд:

- Том болон дунд банкууд ААН болон өрхийн зээлийн шалгуураа төдийлөн өөрчлөхгүй бол дунд банкууд өрхийн зээл харин жижиг банкууд ААН зээлийн шалгуураа бага зэрэг сулруулах төлөвтэй байна;
- Том банкуудын хувьд нийт зээлийн нөхцөлөө төдийлөн өөрчлөх сонирхолгүй байгаа бол дунд болон жижиг банкуудын хувьд зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулна гэсэн хандлагатай байна;
- Банкууд ирэх 3 сард ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ, харин өрхийн зээлийн эрэлт төдийлөн нэмэгдэхгүй гэсэн хүлээлттэй байна.


2 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгааны ажлын зорилго

Энэхүү түүвэр судалгааны зорилго нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкуудын зээлийн үйл ажиллагаа, цаашдын төлөв ямар байгааг тодорхойлоход оршино.

Судалгааны хамрах хүрээ, хугацаа

Зураг 1: Банкуудын зээлийн хэмжээ



- Банкны түүвэр судалгааг 2017 оны II улиралд Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй нийт 12 банкуудын дунд гүйцэтгэв.
- Уг түүвэр судалгааг банкны зээлийн үйл ажиллагаа хариуцсан, шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтнуудын дунд хийсэн.
- Судалгаанд оролцсон банкуудыг зээлийн хэмжээгээр нь том, дунд, жижиг гэж ангилан, судалгааны үр дүнг нийт банкууд болон дээрх ангиллаар задлан харууллаа.

Эх сурвалж: Монголбанк

Аргазүйн товч тайлбар

Банкны зээлийн төлөвийн судалгаа нь (i) зээлийн шалгуур, (ii) нөхцөл болон (iii) эрэлт гэсэн үндсэн гурван бүлэг асуултуудаас бүрдэнэ. Судалгааны үр дүнг нэгтгэхдээ банкуудын хариултуудад 5 интервал бүхий $[-1; +1]$ хоорондох утгуудыг харгалзуулж өгнө. Ингэхдээ банк тус бүрийн зээлийн үлдэгдлүүдийн хувийн жинг ашиглаж том, дунд болон жижиг банкуудын хувьд жигнэсэн дундаж индексийг тооцох замаар нийт системийн хувьд чиглэлийн индексийг тооцсон.

Хүснэгт 2: Индексийн тооцоолол

Индексийн утга	-1.0	-0.5	0	0.5	1.0
Зээлийн шалгуур	Нэлээд суларсан	Бага зэрэг суларсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан	Нэлээд чангарсан
Зээлийн нөхцөл	Нэлээд суларсан	Бага зэрэг суларсан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан	Нэлээд чангарсан
Зээлийн эрэлт	Нэлээд багассан	Бага зэрэг багассан	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдсэн	Нэлээд нэмэгдсэн


3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 Өнгөрсөн 3 сарын хугацаан дахь зээлийн төлөв:

Зээлийн шалгуур

Нийт банкуудын хувьд өнгөрсөн 3 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн** шалгуураа бага зэрэг чангаруулсан байна. Тэр дундаа ХАА, уул уурхай, боловсруулах болон худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулсан бол **барилгын салбарын** зээлийн шалгуураа нэлээд чангаруулжээ. Барилгын салбарын зогсонги байдал болон орон сууцны үнийн бууралт үргэлжилсэн хэвээр байгаа нь банкууд барилгын салбарын зээлийн шалгуураа чангаруулахад нөлөөлсөн байх талтай юм. Харин дунд банкуудын хувьд ААН-ийн зээлийн шалгуураа огт өөрчлөөгүй байна /Зураг 2, Зураг 3/.


Зураг 2: ААН-ийн зээлийн шалгуур, /банкуудаар/ Зураг 3: ААН-ийн зээлийн шалгуур, /салбараар/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Ийнхүү нийт банкуудын хувьд ААН-ийн зээлийн шалгуураа чангаруулахад эдийн засгийн өсөлтийн сааралт, валютын ханш, тухайн салбарын төлөв байдал зэрэг нь голлон нөлөөлжээ /Зураг 4 /.

Зураг 4: ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс





Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Нийт банкуудын хувьд өнгөрсөн 3 сарын хугацаанд **өрхүүдэд олгох зээлийн** шалгуураа төдийлөн өөрчлөөгүй байна. Харин банкуудыг хэмжээгээр нь нарийвчлан авч үзвэл жижиг банкуудын хувьд өрхийн зээл тэр дундаа цалин, тэтгэвэр, малчны зээлийн шалгуураа бага зэрэг сулруулжээ /*Зураг 5, Зураг 6*/.

Зураг 5: Өрхийн зээлийн шалгуур, /банкуудаар/


Зураг 6: Өрхийн зээлийн шалгуур, /зориулалтаар/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Жижиг банкуудын хувьд өрхийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулахад харилцагчийн төлбөрийн чадвар, барьцаа хөрөнгийн эрсдэл зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна /*Зураг 7*/.

Зураг 7: Өрхийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс




Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Зээлийн нөхцөл

Судалгаанд хамрагдсан нийт банкууд өнгөрсөн 3 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн** хэмжээг бууруулах болон барьцаа хөрөнгийн үнэлгээг, зээлдэгчийн гэрээгээр хүлээх үүргийг нэмэгдүүлэх зэргээр зээлийн нөхцөлүүдийг бага зэрэг чангаруулсан байна. Харин банкууд зээлийн хүү болон зээлийн хугацаанд төдийлөн өөрчлөлт оруулаагүй байна /*Зураг 8*/.


Зураг 8: ААН-ийн зээлийн нөхцөл /хэмжээгээр/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Нийт банкуудын хувьд **өрхийн зээлийн нөхцөлд** төдийлөн өөрчлөлт оруулаагүй байна. Гэвч жижиг болон дунд банкууд нь том банкуудтай харьцуулахад зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, хугацааг уртасгах зэргээр зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан байна /Зураг 9/.

Зураг 9: Өрхийн зээлийн нөхцөл /хэмжээгээр/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк



Зээлийн эрэлт

Өнгөрсөн 3 сарын хугацаанд нийт банкны системийн хувьд **ААН-ийн зээлийн эрэлт** төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Харин банкуудыг хэмжээгээр нь авч үзвэл том банкуудын зээлийн эрэлт бага зэрэг өссөн бол дунд болон жижиг банкуудын зээлийн эрэлт бага зэрэг буурсан байна /Зураг 10/.

ААН-ийн зээлийн эрэлтийг салбараар нь авч үзвэл уул уурхай болон худалдаа үйлчилгээний салбар дахь зээлийн эрэлт өссөн бол хөдөө аж ахуйн салбар дахь зээлийн эрэлт буурчээ /Зураг 11/.

Зураг 10: ААН-ийн зээлийн эрэлт, /банкуудаар/

Зураг 11: ААН-ийн зээлийн эрэлт, /салбараар/





Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Нийт банкуудын хувьд **өрхийн зээлийн эрэлт** тэр дундаа хэрэглээ, цалин, малчны зээлийн эрэлт бага зэрэг өссөн байна. Харин банкуудын хувьд иргэдийн бизнесийн зээлийн эрэлт буурсан гэж хариулжээ /Зураг 12, Зураг 13/.

Зураг 12: Өрхийн зээлийн эрэлт, /банкуудаар/

Зураг 13: Өрхийн зээлийн эрэлт, /зориулалтаар/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк



3.2 Ирэх 3 сарын хугацаан дахь зээлийн төлөвийн хүлээлт

Зээлийн шалгуур

Нийт банкны системийн хувьд ирэх 3 сарын хугацаанд ААН-ийн зээлийн шалгуурыг чангаруулахгүй гэж хариуллаа /Зураг 14/. Харин хэмжээгээр нь авч үзвэл жижиг банкууд ХАА-н салбар дахь зээлийн шалгуураа бага зэрэг сулруулах бол барилгын салбарын зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулах төлөвтэй байна /Зураг 15/.

Зураг 14: ААН-ийн зээлийн шалгуур, /банкуудаар/

Зураг 15: ААН-ийн зээлийн шалгуур, /салбараар/





Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Нийт банкуудын хувьд өрхийн зээлийн шалгуураа төдийлөн өөрчлөхгүй байх төлөвтэй байна. Харин дунд банкуудын хувьд том болон жижиг банкуудтай харьцуулахад бага зэрэг сулруулах төлөвтэй байна /*Зураг 16*/.

Зураг 16: Өрхийн зээлийн шалгуур, /банкуудаар/

Зураг 17: Өрхийн зээлийн шалгуур /зориулалтаар/




Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Зээлийн нөхцөл

Нийт банкуудын хувьд ирэх 3 сарын хугацаанд **ААН-ийн зээлийн нөхцөлийг** төдийлөн өөрчлөх төлөвгүй байна. Харин банкуудаар авч үзвэл том банкууд барьцаа хөрөнгийн үнэлгээ, шаардлага нэмэгдүүлнэ гэж хариулсан бол жижиг банкууд хувьд зээлийн хэмжээг өсгөж, хугацааг уртасгаж, хүүг бууруулж зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулна гэжээ /*Зураг 18*/.


Зураг 18: ААН-ийн зээлийн нөхцөл, ирэх 3 сард /хэмжээгээр/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Том банкуудын хувьд ирэх 3 сарын хугацаанд **өрхийн зээлийн нөхцөлөө** өөрчлөх сонирхолгүй байгаа бол дунд болон жижиг банкуудын хувьд зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулах төлөвтэй байна /*Зураг 19*/.

Зураг 19: Өрхийн зээлийн нөхцөл, ирэх 3 сард





Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Зээлийн эрэлт

Нийт банкууд ирэх 3 сард ААН-үүдийн бизнесийн идэвхжил сэргэж ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна /Зураг 20/. Харин дунд банкуудын зээлийн эрэлт төдийлөн нэмэгдэхгүй гэж үзжээ.

Зураг 20: ААН-ийн зээлийн эрэлт, /банкуудаар/

Зураг 21: ААН-ийн зээлийн эрэлт, /салбараар/





Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Нийт банкууд ирэх 3 сард өрхийн зээлийн эрэлт төдийлөн нэмэгдэхгүй гэсэн хүлээлттэй байна /Зураг 22/.

Зураг 22: Өрхийн зээлийн эрэлт, /банкуудаар/

Зураг 23: Өрхийн зээлийн эрэлт, /зориулалтаар/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

3.3 Бусад асуултууд

Эдийн засгийн идэвхжил буурсан, зах зээлийн эрсдэл нэмэгдсэн, валютын ханшийн тогтворгүй байдал нь ААН-ийн зээлийн нийлүүлэлт буурахад голлон нөлөөлсөн гэж үзжээ /*Зураг 24*/. Харин өрхийн зээлийн нийлүүлэлт буурахад өөрийн хөрөнгийн хүрэлцээ муудсан, эх үүсвэрийн зардал, зах зээлийн эрсдэл нэмэгдсэн зэрэг хүчин зүйлсүүд нөлөөлсөн байна /*Зураг 25*/.

Зураг 24: ААН-ийн зээлийн нийлүүлэлт буурахад нөлөөлөгч хүчин зүйлс, /давхардсан тоогоор/



Зураг 25: Өрхийн зээлийн нийлүүлэлт буурахад нөлөөлөгч хүчин зүйлс, /давхардсан тоогоор/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк

Бараа бүтээгдэхүүний борлуулалт муудсан, бизнесийн үйл ажиллагаа хумигдсан болон түүхий эд материалын зардал өссөн нь ААН-ийн зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж байна гэж банкууд хариулжээ /*Зураг 26*/.

Харин өрхийн зээлийн эргэн төлөлт муудахад бараа бүтээгдэхүүний борлуулалт муудсан, бизнесийн үйл ажиллагаа хумигдсан болон зээлийн хугацаа богино зэрэг нь сөргөөр нөлөөлж байна гэж банкууд хариулжээ /*Зураг 27*/.

Зураг 26: ААН-ийн зээлийн эргэн төлөлт буурахад нөлөөлөгч хүчин зүйлс, /давхардсан тоогоор/



Зураг 27: Өрхийн зээлийн эргэн төлөлт муудахад нөлөөлөгч хүчин зүйлс, /давхардсан тоогоор/



Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн судалгаа, Монголбанк